



СҮЛД-АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл хяналтын итгэмжлэгдсэн
байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИДЭД

Дүгнэлт

Бид “Номин юнити ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “Номин юнити ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх материаллаг зүйлсийг хамруулан үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага Тойруу, 8-р хороо, 11-р хороолол,
GB Центр #502

И-мэйл: info@suld-audit.mn
suldaudit2024@gmail.com
Веб: www.suld-audit.mn

Факс: 976-70118016
Тел: 976-99114056

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


СҮҮД-АУДИТ-ХХК


Ч.ГҮНДБАЯР
УГК0322
Захирал 2007956
ММНБ
2026 оны 3 дугаар сарын 23

**“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх**

Үзүүлэлтүүд	(төгрөгөөр)	
	2024/12/31	2025/12/31
1. Санхүүгийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,064,102,036.13	2,675,474,446.16
Зээл	40,303,604,857.28	60,462,440,487.30
Хөрөнгө оруулалт	33,861,920.00	33,861,920.00
Бусад санхүүгийн хөрөнгө	30,051,206.54	28,944,677.37
Санхүүгийн хөрөнгийн дүн	41,431,620,019.95	63,200,721,530.83
2. Санхүүгийн бус хөрөнгө		
Татвар, НДШ-ийн авлага	2,443,797.84	2,911,519.56
Үндсэн хөрөнгө	76,594,756.29	94,384,006.97
Бусад санхүүгийн бус хөрөнгө	35,858,657.85	31,832,880.34
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	114,897,211.98	129,128,406.87
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	41,546,517,231.93	63,329,849,937.70
3. Санхүүгийн өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	4,779,436,051.98	18,042,666,187.48
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	3,172,738,954.30	6,792,540,032.68
Бусад санхүүгийн өр төлбөр	103,408,647.42	292,120,790.44
Санхүүгийн өр төлбөрийн дүн	8,055,583,653.70	25,127,327,010.60
4. Санхүүгийн бус өр төлбөр		
Татвар, НДШ-ийн өр төлбөр	298,695,495.45	285,216,490.98
Бусад санхүүгийн бус өр төлбөр	-	-
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	298,695,495.45	285,216,490.98
Нийт өр төлбөрийн дүн	8,354,279,149.15	25,412,543,501.58
5. Эздийн өмч		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	22,500,000,000.00	22,500,000,000.00
Өмчийн бусад хэсэг	-	1,705,804,468.98
Хуримтлагдсан ашиг/алдагдал	10,692,238,082.78	13,711,501,967.14
Эздийн өмчийн дүн	33,192,238,082.78	37,917,306,436.12
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	41,546,517,231.93	63,329,849,937.70


Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх**

Үзүүлэлтүүд	(төгрөгөөр)	
	2024/12/31	2025/12/31
Хүүгийн орлого	7,251,989,441.27	14,203,726,409.55
Банканд байршуулсан хөрөнгийн	76,873,350.74	14,842,911.50
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	41,727,932.29	9,065,359.12
Зээлийн	7,133,388,158.24	14,179,818,138.93
Хүүгийн зардал	234,746,156.35	3,182,310,487.99
Итгэлцлийн үр шим	183,068,106.80	1,584,027,247.57
Зээлийн	51,678,049.55	1,598,283,240.42
Цэвэр хүүгийн орлого	7,017,243,284.92	11,021,415,921.56
Эрсдэлийн сангийн зардал	703,339,671.68	2,377,227,534.21
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	6,313,903,613.24	8,644,188,387.35
Бусад орлого	1,482,194,307.97	529,103,093.25
Хүүгийн бус орлого	1,351,688,104.19	376,461,678.95
Бусад орлого, олз	130,506,203.78	152,641,414.30
Бусад зардал	3,370,532,246.18	3,892,930,830.70
Хүүгийн бус зардал	3,363,850,203.18	3,846,376,904.70
Бусад зардал, гарз	6,682,043.00	46,553,926.00
Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг/алдагдал	4,425,565,675.03	5,280,360,649.90
Орлогын татварын зардал	460,768,135.00	555,292,296.56
Тайлант хугацааны цэвэр ашиг/алдагдал	3,964,797,540.03	4,725,068,353.34


Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх**

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	(төгрөгөөр) Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	12,500,000,000.00		6,727,440,542.75	19,227,440,542.75
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Залруулсан үлдэгдэл	12,500,000,000.00		6,727,440,542.75	19,227,440,542.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт				-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн цэвэр ашиг			3,964,797,540.03	3,964,797,540.03
Ногдол ашиг				-
Хувьцаат капиталын өсөлт	10,000,000,000.00			10,000,000,000.00
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	22,500,000,000.00		10,692,238,082.78	33,192,238,082.78
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,705,804,468.98)	(1,705,804,468.98)
Залруулсан үлдэгдэл	22,500,000,000.00		8,986,433,613.80	33,192,238,082.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт				-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн цэвэр ашиг			4,725,068,353.34	4,725,068,353.34
Ногдол ашиг				-
Өмчид гарсан өөрчлөлт		1,705,804,468.98		1,705,804,468.98
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	22,500,000,000.00	1,705,804,468.98	13,711,501,967.14	37,917,306,436.12

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



**“НОМНИ ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх**

		(төгрөгөөр)	
№	Үзүүлэлтүүд	2024/12/31	2025/12/31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	50,407,800,365.22	70,894,512,525.80
	Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	41,110,509,571.87	52,817,333,843.83
	Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	8,737,272,054.80	17,624,993,993.97
	Бусад	560,018,738.55	452,184,688.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	62,902,221,445.22	67,919,228,333.80
	Олгосон зээл	53,177,469,927.05	64,589,481,716.99
	Буцаан олгосон итгэлцэл, үр шим	4,140,904,109.60	543,719,032.09
	Ажиллагаадад олгосон	910,899,959.91	1,387,315,622.86
	Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	766,028,218.00	1,179,975,708.76
	Ашиглалтын зардалд төлсөн	1,409,824.05	-
	Бусад	3,905,509,406.61	218,736,253.10
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,494,421,080.00)	2,975,284,192.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,592.94	25,546,908.49
	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
	Хүлээн авсан ногдол ашиг	4,592.94	25,546,908.49
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	62,486,922.04	98,731,101.11
	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	62,486,922.04	74,822,830.49
	Бусад	-	23,908,270.62
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(62,482,329.10)	(73,184,192.62)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	32,142,000,000.00	97,877,541,401.00
	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	22,142,000,000.00	97,877,256,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,000,000,000.00	-
	Бусад	-	285,401.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,013,691,410.32	99,338,198,950.41
	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	19,013,691,410.32	99,338,198,950.41
	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,128,308,589.68	(1,460,657,549.41)
	Валютын ханшийн зөрүү	(36,683,832.31)	169,929,960.06
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	534,721,348.27	1,611,372,410.03
4.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	529,380,687.86	1,064,102,036.13
4.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,064,102,036.13	2,675,474,446.16

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

